



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/12

Арвайхээр

**Сонгон шалгаруулалт зохион байгуулах
тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” 67 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн 2.17, 2.18 дахь заалтууд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/166 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн эмнэлэг хөдөлмөр магадлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын сонгон шалгаруулалтыг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсугай.

2.Сонгон шалгаруулалт явуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Сонгон шалгаруулалтад тэнцсэн эмч нарын материалыг журмын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөр магадлалын төв комисст 2022 оны 02 дугаар сарын 20-ны дотор хүргэхийг комиссын дарга (Н.Норгинбадам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0025

Аймгийн Засаг даргын 2022 оны...
дугаар сарын ...-ны өдрийн...
дугаар захирамжийн хавсралт



**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ХИЙХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

**Дарга: Н.Норгинбадам (аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын
хэлтсийн дарга)**

**Нарийн бичгийн дарга: С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх
Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт,
шалгалтын байцаагч)**

**Гишүүд: Д.Шиваанүрдэв (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн
газрын дарга)**

**Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга)**

**Р.Наранцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)**

-оОо-